

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн
Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тухай

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээ туссан.

Хоёр. Үнэлгээний дүн

Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 6 төсөл туссанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлттэй 2, 85 хувийн биелэлттэй 1, 71 хувийн биелэлттэй 1, 63 хувийн биелэлттэй 1, Засгийн газрын тогтоолоор чиг үүргийн дагуу өөр байгууллагад шилжсэн 1 арга хэмжээ тус тус байна. Нийт дундаж үнэлгээгээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **83.8** хувийн биелэлттэй байна.

Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 216 тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор”-ын төсөл, арга хэмжээг хариуцсан чиг үүргийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албанд шилжүүлсэн тул уг төсөл, арга хэмжээг дундаж үнэлгээнд оруулаагүй хасч тооцсон болно.

Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний хэрэгжилт
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Төсөл, хөтөлбөр	Хэрэгжилт	Нийт санхүүжилт /%I	2024 оны гүйцэтгэлийн Үнэлгээ	Тайлбар
1	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл	Төслийн хэрэгжилт 100 хувь.	100	100	2021 онд бүрэн хэрэгжиж дууссан
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Төслийн хэрэгжилт 100 хувь	100	100	2022 онд бүрэн хэрэгжиж дууссан.
3	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	Төслийн ажлын явц 90 хувь. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ.	81	63	2025 онд хэрэгжиж дуусна.
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл	Төслийн ажлын явц 75 хувь. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ.	74.3	71	2026 онд хэрэгжиж дуусна.
5	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2	Төслийн ажлын явц 90 хувь. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ.	95	85	2025 онд хэрэгжиж дуусна.
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор	Төслийн ажлын явц 30 хувь. Төслийн ажил шилжсэн.	0	-	Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороонд чиг үүргийн хүрээнд шилжсэн.
Нийт				83.8	

2024 онд хэрэгжсэн төслүүдийн товч мэдээлэл:

Д/д	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Санхүүжилтийн нийт дүн	Төсөв /2024/	Гүйцэтгэлийн дүн /2024.12.20-ны байдлаар/	Төслийн хугацаа		ТХН-ийн ажилтны тоо
						Эх-лэх	Дуусах	
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	Азийн хөгжлийн банк, Японы	27.27 сая ам доллар	6.39 тэрбум	5.89 тэрбум төгрөг	2018	2026	9

	оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл	ядуурлыг бууруулах сан		төгрөг				
2	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2	Азийн хөгжлийн банк	73 сая ам доллар	46.4 сая ам доллар	44 сая ам доллар	2021	2025	5
3	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	Дэлхийн банк	20.0 сая ам доллар	22.0 тэрбум төгрөг	18.3 тэрбум төгрөг	2020	2025	8

Гурав. Дүгнэлт, зөвлөмж

1. “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн “Ковид-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан заавал албан журмын даатгуулагчдад тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ” зорилт 100 хувь хэрэгжсэн. Бусад 3 зорилтын хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй 50-70 хувийн биелэлттэй байна. Төлөвлөсөн зорилт арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тодорхойлж, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг бүрэн хангах;
2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл”-ийн хэрэгжих хугацааг шинээр 1 аймаг 1 дүүрэгт баригдах хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв (ХБХХТ)-ийн 2 барилгын ажилтай холбоотой 2026 оны 10 дугаар сарыг дуустал сунгасан байна.
Төслийн 2024 онд төлөвлөсөн зарим арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:
 - Архангай аймгийн ХБХХТ-ийн 1 барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах,
 - Завхан аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт шинээр нэмж барих ХБХХТ-ийн 2 барилгын зураг төсөв боловсруулж, магадлалын нэгдсэн дүгнэлт хийлгэх,
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын "Мэргэжлийн боловсролын ур чадвар олгох сургуулийн үйл ажиллагааны стратеги" бодлогын баримт бичгийн төслийг эцэслэж холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргүүлэх,

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтын тендерийн баримт бичгийн төсөл боловсруулах,
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн мэргэжилтнүүдэд чадавх бэхжүүлэх сургалт хийх,
3. “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”-ийн хамрах хүрээнд өөрчлөлт орж, шинэ арга хэмжээнүүд нэмэгдсэнтэй холбоотой төслийн хэрэгжих хугацааг 2025 оны 08 дугаар сарыг дуустал сунгасан байна. 2024 оны эцсийн байдлаар ажлын явц, хэрэгжилт 90 хувь, санхүүжилтийн нийт гүйцэтгэл 95 хувьтай байна.
- Төслийн 2024 онд төлөвлөсөн зарим арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:
- Нэмэлтээр шаардлагатай байгаа амьжиргаа дэмжих тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг эцэслэн тодорхойлж, худалдан авах. Техникийн ур чадвар олгох сургалт явуулах,
 - Нийгмийн халамжийн эрх зүйн шинэчлэл, ядуурлыг бууруулах хүрээнд гадаад орны туршлага (Төгсөлтийн аргачлалын хөтөлбөрийн сайн хэрэгжүүлж буй Филиппин, Индонези улсуудын)-аас судлах;
4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор”-ийн барилгыг БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барьж байгуулах төсөл Засгийн газрын 2024 оны 216 дугаар тогтоолоор хариуцсан чиг үүргийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албанд шилжсэнтэй холбоотой барилгын газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүдтэй холбоотой баримт материалыг бүрэн хүлээлгэж өгч, шаардлагатай мэдээллээр ханган ажиллах;
5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг яамны холбогдох бодлогын газрууд хяналтад авч, төслийн нэгжтэй хамтарсан үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагыг сайжруулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, нягт хамтарч ажиллах;
6. Төсөл, арга хэмжээний биелэлтийг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах, тайланд арга хэмжээний явцыг бус үр дүнг тайлагнах.